

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ИДЭВХГҮЙ ШУГАМ, СҮЛЖЭЭГ ХАМТРАН АШИГЛАХ ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү дүрмийн зорилго нь харилцаа холбооны зөвшөөрөл эзэмшигчид (цаашид “зөвшөөрөл эзэмшигчид” гэх)-ийн Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтийн үйлчилгээний зориулалтаар байгуулсан харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг үр ашиггүй хөрөнгө оруулалтыг багасгах, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах, шударга өрсөлдөөнийг дэмжих хүрээнд өөр хоорондоо хамтран ашиглах үйл ажиллагааг шуурхай, нээлттэй зохион байгуулахад оршино.
- 1.2 Энэ дүрмээр Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтийн үйлчилгээний зориулалтаар харилцаа холбооны шугам, сүлжээ байгуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид (цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх)-ийн идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглахад тавигдах шаардлага, хүлээх үүргийг тодорхойлж, харилцаа холбооны шугам, сүлжээг хамтран ашиглах үйл ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.3 Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтийн үйлчилгээний зориулалтаар харилцаа холбооны сүлжээ байгуулсан зөвшөөрөл эзэмшигчид нь харилцаа холбооны шугам, сүлжээг хамтран ашиглахдаа энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.
- 1.4 Нийтийн үйлчилгээний зориулалтаар харилцаа холбооны шугам, сүлжээг байгуулж, түүнийг бусдын эзэмшил, ашиглалтад шилжүүлж, ашгийн төлөө үндсэн бизнесийн үйл ажиллагаатай тусгай зөвшөөрөл эзэмшигчийн харилцаа холбооны шугам, сүлжээг бусдын эзэмшил, ашиглалтад шилжүүлэх үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулахгүй.
- 1.5 Харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн өмчлөлийн нийтийн үйлчилгээний зориулалтаар байгуулсан идэвхгүй шугам, сүлжээнд хамаарна.
- 1.6 Энэхүү дүрэмд тусгагдсан нэр томъёо нь Иргэний хууль, Харилцаа холбооны тухай хууль болон бусад эрх зүйн актуудад нийцсэн байна.

ХОЁР. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ШУГАМ, СҮЛЖЭЭНИЙ АНГИЛАЛ

- 2.1 Харилцаа холбооны шугам, сүлжээг дараах байдлаар ангилна.

- 2.1.1 Идэвхтэй шугам, сүлжээ;

2.1.2 Идэвхгүй шугам, сүлжээ.

2.2 Мэдээлэл дамжуулахад шууд оролцдоггүй байр талбай, цамхаг, худаг сувагчлал, агааржуулалтын систем, зай тэжээл, дохиоллын систем зэрэг сүлжээний идэвхгүй хэсгийг идэвхгүй шугам, сүлжээнд хамааруулан ойлгоно.

ГУРАВ. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ИДЭВХГҮЙ ШУГАМ, СҮЛЖЭЭ

3.1 Төлбөр тооцоог тусад нь тооцох боломжтой, байр талбай, цамхаг, агааржуулалтын систем, галын дохиоллын систем, зай тэжээл зэрэг шугам, сүлжээний бие даасан нэг хэсгийг сүлжээний элементэд хамааруулна.

3.2 Энэхүү дүрмийн харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээнд дараах сүлжээний элементүүд хамаарна.

3.2.1 Инженерийн барилга байгууламж;

3.2.2 Шон, багана;

3.2.3 Хуваарилах шүүгээ, хайрцаг;

3.2.4 Цамхаг;

3.2.5 Сайт;

3.2.6 Эрчим хүчний эх үүсвэр;

3.2.7 Агааржуулалтын систем;

3.2.8 Дохиолол хамгаалалтын систем;

3.2.9 Байр талбай, зогсуур;

3.2.10 Хэрэглэгчийн сүлжээ.

ДӨРӨВ. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ИДЭВХГҮЙ ШУГАМ, СҮЛЖЭЭГ ХАМТРАН АШИГЛАХ

4.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн өмчлөлийн харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд энэхүү дүрмийг баримтлан Иргэний хуульд заасан бусдын эзэмшил, ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээг хуульд заасан шаардлагыг ханган бичгээр байгуулан хамтран ашиглана.

- 4.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн харилцаа холбооны үйлчилгээг хэрэглэгчдэд тасралтгүй, найдвартай хүргэхээр идэвхгүй шугам, сүлжээний тодорхой хэсгийг тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу тухай бүр нөөцийг бүрдүүлж тоног төхөөрөмжийг суурилуулах, холболт, тохируулгыг хийсэн байна.
- 4.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээний нийт багтаамжийн 10 хувийг зайлшгүй хэрэгцээнд зориулан нөөцөлнө.
- 4.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэхүү дүрмийн 4.2, 4.3 дахь хэсгүүдэд зааснаас бусад нөөц бүрдүүлэлтэд чиглэсэн ямар нэгэн арга хэмжээ авагдаагүй буюу холболт, тохируулга хийгдээгүй хэсгийг нөөц гэж үзэхгүй.
- 4.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү дүрмийн 4.2, 4.3 дахь хэсгүүдэд зааснаас гадна хүсэлт гаргасан идэвхгүй шугам, сүлжээг эхэнд хүсэлт гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран ашиглахаар шийдвэрлэсэн, хүсэлт гаргасан этгээд нь өмнө нь идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглахдаа төлбөр тооцооны үлдэгдэлтэй тохиолдолд идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглахаас татгалзаж болно.
- 4.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн сүлжээний элементийн аюулгүй байдлыг хангах, бусад үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний элементийн аюулгүй байдал, нууцлалыг хадгалах зорилгоор өөрийн байр талбайд нэвтрэн орж ашиглалт үйлчилгээ, хэмжилт шалгалт хийх зэрэг үйл ажиллагааг зохицуулсан аюулгүй ажиллагааны журмыг боловсруулан, баталж, хамтран ашиглах гэрээнд мөрдөж ажиллах талаар тусгана.
- 4.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хамтран ашиглаж буй идэвхгүй шугам, сүлжээнд нэвтэрч ашиглалт үйлчилгээ эрхлэх тохиолдолд бусад үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний элементэд гэмтэл саатал учруулахгүй байж, энэхүү дүрмийн 4.6 дахь хэсэгт заасан дэгийг баримтлан ажиллана.

ТАВ. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ИДЭВХГҮЙ ШУГАМ, СҮЛЖЭЭГ ХАМТРАН АШИГЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ШИЙДВЭРЛЭХ

- 5.1 Харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах сонирхолтой тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “хүсэлт гаргагч үйлчлэгч” гэх) нь бусад нийтийн үйлчилгээний зориулалтаар байгуулсан харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг өмчлөгч тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “хүлээн авагч үйлчлэгч” гэх)-ээс харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах хүсэлтийг албан бичгээр хүргүүлнэ.
- 5.2 Энэхүү дүрмийн 5.1 дэх хэсэгт заасан хүсэлт хүргүүлэх албан бичигт дараах зүйлсийг тусгана.

- 5.2.1 Хамтран ашиглах идэвхгүй шугам, сүлжээний тодорхой байршил;
 - 5.2.2 Хамтран ашиглах идэвхгүй шугам, сүлжээний нэгж, тоо хэмжээ;
 - 5.2.3 Хамтран ашиглах хугацаа.
- 5.3 Хүсэлт гаргагч нь идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах хүсэлтийг хүлээн авагч талд хүргүүлэхдээ хүлээн авагч талын бичиг хэрэг хариуцсан ажилтанд энэхүү дүрмийг баримтлан хүргэх бөгөөд албан бичгийн гаднах битүүмжлэл дээр идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах хүсэлт болохыг тэмдэглэнэ.
- 5.4 Хүлээн авагч үйлчлэгч нь хүсэлтийг хүлээн авч, хүлээн авсан өдрийг тэмдэглэж, идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах боломжтой эсэх талаар судалж, хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан албан бичгээр хариу хүргүүлнэ.
- 5.5 Хүлээн авагч үйлчлэгч нь хүсэлт гаргаж буй албан бичгийг шуудангаас бусад хэрэгслээр хүлээн авсан тохиолдолд албан бичгийг хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутыг тэмдэглэсэн акт (нотломж)-ыг 2 хувь үйлдэж, 1 хувийг албан бичиг хүргэсэн этгээдэд өгнө.
- 5.6 Энэхүү дүрмийн 5.4 дахь хэсэгт заасан хүсэлтийг шийдвэрлэж хариу өгөхдөө эхэлж ирсэн хүсэлтийг эхэнд шийдвэрлэнэ.
- 5.7 Энэхүү дүрмийн 5.4 дахь хэсэгт заасан хариу албан бичигт дараах зүйлсийг тусгана.
- 5.7.1 Хамтран ашиглах идэвхгүй шугам, сүлжээний нэгж тариф, нийт үнэ;
 - 5.7.2 Хүсэлт гаргасан хугацаанд идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах боломжтой эсэх;
 - 5.7.3 Хүсэлт гаргасан идэвхгүй шугам, сүлжээний нэгж, тоо хэмжээгээр хамтран ашиглах боломжтой эсэх;
 - 5.7.4 Хамтран ашиглах идэвхгүй шугам, сүлжээний техникийн нөхцөл;
 - 5.7.5 Гэрээ байгуулах үйл ажиллагааны мэдээлэл.
- 5.8 Энэхүү дүрмийн 4.5 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглахаас татгалзахгүй бөгөөд энэ тохиолдолд татгалзсан хариуг энэ дүрмийн 5.4 дахь хэсэгт заасан хугацаа, хэлбэрээр хариу өгнө.

- 5.9 Хамтран ашиглах гэрээг хариу албан бичгийг шууданд өгсөн эсхүл тухайн байгууллагад хүргүүлсэн өдрөөс эхлэн нийт ажлын 21 хоногт багтаан байгуулна.
- 5.10 Энэхүү дүрмийн 5.9 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан гэрээ байгуулаагүй бол хүсэлт гаргагч үйлчлэгчийн гомдлоор Зохицуулах хороо энэхүү дүрэмд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 5.11 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээ хамтран ашиглах гэрээнд талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор уг гэрээ болон түүний хавсралтын хуулбар, холбогдох материалын хамт Зохицуулах хороонд албан бичгээр ирүүлж бүртгүүлнэ.
- 5.12 Энэхүү дүрмийн 5.11 дэх хэсэгт заасан гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 7 хоногийн дотор нэмэлт, өөрчлөлтийг Зохицуулах хороонд албан бичгээр ирүүлж, бүртгүүлнэ.
- 5.13 Хамтран ашиглах гэрээнд зааглах цэгийг заавал тогтоосон байна.
- 5.14 Хүлээн авагч үйлчлэгч нь харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах техникийн нөхцөл, үнэ тариф, гэрээ хийх үйл явцын талаарх мэдээллийг бусдад нээлттэй байлгаж, өөрийн цахим хуудсанд тодорхой харагдахуйц байдлаар байршуулна.

ЗУРГАА. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ИДЭВХГҮЙ ШУГАМ, СҮЛЖЭЭГ ХАМТРАН АШИГЛАХАД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

6.1 Хүсэлт гаргагч үйлчлэгч:

6.1.1 Хүсэлт гаргагч үйлчлэгч нь дараах эрхтэй:

- 6.1.1.1 Харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг нийтийн үйлчилгээний зориулалтаар байгуулан өмчилж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчээс идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах хүсэлт гаргах, шийдвэрлүүлж хариу авах;
- 6.1.1.2 Стандарт болон норматив баримт бичигт заасан шаардлага хангасан харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглахыг хүлээн авагч үйлчлэгчээс шаардах;
- 6.1.1.3 Харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг нийтийн үйлчилгээний зориулалтаар байгуулан өмчилж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү дүрэмд зааснаас бусад шалтгаанаар идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглахаас татгалзсан тохиолдолд Зохицуулах хороонд гомдол гаргах;

- 6.1.1.4 Хүлээн авагч талын буруутай үйл ажиллагаанаас хамааран энэхүү дүрмийн 5.6 дахь хэсэгт заасан хугацаанд гэрээ байгуулагдаагүй тохиолдолд Зохицуулах хороонд гомдол гаргах;
- 6.1.1.5 Хамтран ашиглах хүсэлт гаргаж буй албан бичгийг хүлээн авагч үйлчлэгчид шуудангаас бусад хэрэгслээр хүргэх тохиолдолд уг албан бичгийг хүлээн авсан огноог бүртгэж буй эсэхэд хяналт тавих, зөрчсөн гэж үзвэл Зохицуулах хороонд гомдол гаргах;
- 6.1.1.6 Эхэнд гаргасан хүсэлтийг хүлээн авагч үйлчлэгч эхэнд шийдвэрлээгүй гэж үзсэн эргэлзээ бүхий баримттай тохиолдолд Зохицуулах хороонд гомдол гаргах.

6.1.2 Хүсэлт гаргагч үйлчлэгч нь дараах үүрэгтэй:

- 6.1.2.1 Хүлээн авагч үйлчлэгчийн байгууллагын нууцаар тогтоосон мэдээлэлтэй танилцсан бол Байгууллагын нууцын тухай хуулийн дагуу нууцыг чанд хадгалах үүрэгтэй;
- 6.1.2.2 Бусдын тоног төхөөрөмж, шугам, сүлжээний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөө үзүүлэхгүй байх;
- 6.1.2.3 Хүлээн авагч үйлчлэгчийн идэвхгүй шугам, сүлжээнд өөрийн өмчлөл, эзэмшлийн идэвхгүй шугам, сүлжээ байрлуулсан тохиолдолд түүний аюулгүй байдлыг хангаж цоож түгжээгээр хангах;
- 6.1.2.4 Идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглахдаа түүнд хохирол учруулахгүй байх, өнгө үзэмжийг гэмтээхгүй байх.

6.2 Хүлээн авагч үйлчлэгч:

6.2.1 Хүлээн авагч үйлчлэгч нь дараах эрхтэй:

- 6.2.1.1 Харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг ашиглуулахад хүсэлт гаргагч талыг тусгай зөвшөөрөл эзэмшигч байхыг шаардах;
- 6.2.1.2 Идэвхгүй шугам, сүлжээнд байршуулсан бусдын болон өөрийн төхөөрөмж, байр талбайн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангахыг хүсэлт гаргагч үйлчлэгчээс шаардах;
- 6.2.1.3 Хамтран ашиглах хүсэлтэд хариу хүргүүлэхэд өөрийн байгууллагын нууцаар тогтоосон мэдээллийг хүргэх тохиолдолд өөрийн нууцын журмыг мөрдөж ажиллахыг хүсэлт гаргагч

үйлчлэгчээс шаардах, хяналт тавих, зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороонд гомдол гаргах.

6.2.2 Хүлээн авагч үйлчлэгч нь дараах үүрэгтэй:

6.2.2.1 Харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг энэхүү дүрмийн дагуу хүсэлт гаргагч үйлчлэгчтэй хамтран ашиглах;

6.2.2.2 Хүсэлт гаргагч үйлчлэгчээс ирүүлсэн харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэж, хариу өгөх;

6.2.2.3 Хүсэлт гаргагч үйлчлэгчийн байгууллагын нууцаар тогтоосон мэдээлэлтэй танилцсан бол Байгууллагын нууцын тухай хуулийн дагуу нууцыг чанд хадгалах;

6.2.2.4 Идэвхгүй шугам, сүлжээндээ засвар үйлчилгээ эрхлэх, нүүлгэн шилжүүлэлт зэрэг үйл ажиллагаа явуулах тохиолдолд тухайн идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд урьдчилан мэдэгдэх;

6.2.2.5 Идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах хүсэлт гаргаж буй албан бичгийг ирсэн он, сар, өдрөөр бүртгэх бүртгэл үүсгэх, шуудангаас бусад хэрэгслээр ирүүлсэн хүсэлт гаргаж буй албан бичгийг хүлээн авсан талаар актыг үйлдэж, 1 хувийг хүргэсэн этгээдэд өгөх;

6.2.2.6 Харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах техникийн нөхцөл, үнэ тариф, гэрээ хийх үйл явцын талаархи мэдээллийг бусдад нээлттэй байлгаж, өөрийн цахим хуудсанд тодорхой харагдахуйц байдлаар байршуулах.

ДОЛОО. ҮНЭ ТОГТООХ ЗАРЧИМ

7.1 Хүлээн авагч үйлчлэгч нь харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах үнэ тарифыг тогтоохдоо Зохицуулах хорооноос баталсан үнэ тариф тогтоох зөвлөмж, аргачлалыг баримтална.

7.2 Хүлээн авагч үйлчлэгч нь тухайн зах зээлд зүй ёсны монопол эсхүл давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчээр тодорхойлогдсон бол зүй ёсны монопол болон давамгайлагч байдалтай үйлчилгээний үнэ тарифыг Зохицуулах хороогоор хянуулж, батлуулна.

НАЙМ. ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ БАЙГУУЛАМЖ ЭЗЭМШДЭГ ГОЛЛОХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙГ ТОГТООХ

- 8.1 Зайлшгүй шаардлагатай байгууламжийг “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлага”-ын 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсэгт зааснаар ойлгоно.
- 8.2 Голлох үйлчилгээ эрхлэгчийг “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлага”-ын 5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсэгт зааснаар ойлгоно.
- 8.3 Зайлшгүй шаардлагатай байгууламж, түүнийг өмчлөгч голлох үйлчилгээ эрхлэгчийг Зохицуулах хороо тухай бүр тогтоол гарган тогтооно.
- 8.4 Зайлшгүй шаардлагатай байгууламж эзэмшдэг голлох үйлчилгээ эрхлэгч нь зайлшгүй шаардлагатай байгууламжаар тогтоосон идэвхгүй шугам, сүлжээг хамтран үүрэгтэй ба дараах нөхцөлүүдийг хангана. Үүнд:
- 8.5 Зайлшгүй шаардлагатай байгууламжаар тогтоосон харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээний мэдээллийг ил тод мэдээлнэ;
- 8.6 Техникийн нөхцөл шаардлага, үнэ тарифын хувьд үл ялгаварлах;
- 8.7 Өөрийн ижил төрлийн үйлчилгээ, эсхүл өөрийн салбар болон харьяа байгууллагын ижил төрлийн үйлчилгээнд олгодгоос дутуугүй чанарыг үзүүлэх;
- 8.8 Идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах нь ил тод, бодитой, эдийн засгийн бололцоог тооцсон, өртөгт баримжаалсан (техникийн стандарт, шаардлагыг оролцуулан) үнэ тарифтай байх ба энэ нь тухайн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагагүй сүлжээний бүрдэл, эсхүл байгууламжид төлбөр төлөхгүйгээр ашиглах хэмжээнд хүртэл хангалттай хэсэгчилсэн байна.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ БОЛОН ХАРИУЦЛАГА

- 9.1 Энэхүү дүрмийн хэрэгжилтэд Зохицуулах хороо хяналт тавина.
- 9.2 Энэхүү дүрмийг зөрчсөн маргаантай асуудлыг маргалдагч талууд шат шатандаа шийдвэрлэхийг оролдох бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.
- 9.3 Маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос баталсан “Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг мөрдлөг болгоно.
- 9.4 Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар гаргах шийдвэрийнхээ тухай урьдчилан талуудад танилцуулж саналыг нь авах, нээлттэй хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх зэргээр ил тод зарчмыг баримтална.

9.5 Энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авна.

9.5.1 Зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх;

9.5.2 Захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авхуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх; Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах;

9.5.3 Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх;

9.5.4 Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох;

9.5.5 Гаргасан зөрчил, зөрчлийг арилгуулахаар авсан арга хэмжээний талаар нийтэд мэдээлэх.

– о О о –